



ХУЖИРТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 100  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030593


## Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / .... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН



Хужирт сумын Монгол Ардын Намын Хорооны тэргүүлэгчдийн  
2020 оны 06 дугаар 21-ний өдрийн хуралдааны 18 тоот тогтоолын хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ СУМЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН  
СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Уриа: Бүтээснээсээ ихийг бүтээе.



Сумын Монгол Ардын намын Хороо нь орон нутгийнхаа нийгэм эдийн засаг, байгаль орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр урд хэрэгжүүлж ирсэн зарим бодлого үйл ажиллагаа улам өргөжүүлэн хэрэгжүүлэх цаашид сум орноо хөгжүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааг 6 бүлэг 51 зорилтоор нэгтгэн боловсруулж сонгогч та бүхэндээ толилуулж байна.

**1. Шинэ бүтээн байгуулалт хөгжлийн тулгуур**

1. Сумын эдийн засгийн үндэс татварын орлого, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
2. Сумын Ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ, авто болон явган хүний зам, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерийн суваг, гэр хороолол, гудамж талбайн хэсэгчилсэн төлөвлөгөөнүүдийг боловсруулан үе шаттай хэрэгжүүлэх,
3. Сумын төвд жишиг хороолол үүсгэн нэгдсэн системд холбогдсон орон сууц болон Хаус хороолол бий болгох,
4. Цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг бий болгон аж ахуйн нэгж, айл өрхийн холбогдох нөхцлийг бүрдүүлэх,
5. Сумын нэгдсэн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, аж ахуй нэгж, айл өрхүүдийг шугамд холбогдох нөхцлийг хангах
6. Сумын доторх хатуу хучилттай авто замыг 4-5км өргөтгөх, “Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан”, “Хужирт-Арвайхээр” чиглэлэийн авто замуудыг шинээр барих, зураг төслийг боловсруулан барьж эхлэх
7. Сумын төвийн үерийн усны даланг засварлан өргөжүүлнэ,
8. Сумын төвийн шороон замын эвдрэлийг засах, тэгшлэх ажлыг зохион байгуулна.
9. Цэцэрлэгт хүрээлэнг тохижуулж, байнгын үйл ажиллагаатай болгох
10. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх спортын ордонтой болох
11. Ахмад настнуудад чөлөөт цаг өнгөрөөх, чийрэгжүүлэх танхим, ахмадын өргөө хүүхэд хөгжлийн төвтэй болох,
12. Орхон голд Мойлтын ам, Хадан булан болон, Хавчилын голд тус тус гүүр барих

**2. Хөдөө аж ахуй хөдөлмөр эрхлэлт**

1. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хөдөөгийн баг тус бүрийг хариуцсан мал эмнэлэгтэй болгоно.
2. Суманд өвс тэжээлийн нөөцийн сан байгуулна.
3. Орон нутагт эрчимжсэн мал аж ахуйг нэмэгдүүлэх , тэжээлийн ургамал тариалж тэжээлийн үйлдвэр байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулна.

  5



4. Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин бус өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах, сумын төвийн дэргэд малчны хороолол үүсгэж газрын асуудлыг шийдвэрлэх
5. Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах цех байгуулах
6. Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрт хөнгөлттэй зээл олгох замаар жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх,
7. “Бизнес хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллана.

### **3. Байгаль-Эх тогтвортой хөгжил**

1. Сумынхаа байгалийн үзэсгэлэнт газрууд, ардын уламжлалт ёс заншлаа сурталчлах арга хэмжээнд малчдыг өргөнөөр оролцуулах.
2. Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Эсгийний баяр”-ыг өргөжүүлэн Орхоны хөндийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
3. Суманд жуулчны бааз, зочид буудал бий болгох. /SPA центр/
4. Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор сумын ногоон байгууламжийг одоогийн түвшнээс 4 дахин нэмэгдүүлнэ.
5. Усны нөөцийг нэмэгдүүлэх, булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг эрчимжүүлж сумын нутаг дэвсгэр дэх бүх булаг, шандыг хашиж хамгаална.
6. Сумын хог хаягдлын нэгдсэн цэгийг дарж тэгшлэн, тохижуулж хог хаягдал дахин боловсруулах байгуулах
7. Суманд хот тохижилтын ажлыг боловсронгуй болгож “Хужирт Эрдэс баялаг” ОНӨААТҮГ-цын үйл ажиллагааг эрчимжүүлж, ус сувгийн аж ахуй байгуулна.
8. Томоохон аж ахуй нэгжүүдтэй хариуцлагын гэрээг жил бүр байгуулж, иргэдэд байгалийн баялагаа хүртэх боломж нөхцлийг бүрдүүлэн ажиллана.

### **4. Нийгмийн бодлого-Хүний хөгжил**

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
2. Сумын Эрүүл Мэндийн төввийг нарийн мэргэжлийн эмчээр хангаж тэдний ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ, эрүүл мэндийн төвийн байрыг өргөтгөн шинэчлэнэ.
3. Сумын эрүүл мэндийн төвийг шаардлагатай, эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмжөөр ханган эмч нарын ур чадварыг дээшлүүлж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулна.
4. Архи тамхины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил, ТББ-тэй хамтран ажиллаж иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ,
5. Ерөнхий боловсролын сургуулийн 440 хүүхдийн суудалтай байранд их засвар хийж ашиглалтанд оруулах, голын зүүн талд 5дугаар багт сургуулийн хичээлийн байр шинээр барих.
6. ЕБС-ийн байгалийн ухааны, сэтгэн бодох техникийн сэтгэлгээг хөгжүүлэх инженер технологи, мэдээллийн технологийн кабинетуудыг бий болгоно.
7. Багш боловсон хүчний мэргэжил, боловсрол ур чадварыг нэмэгдүүлнэ.
8. Голын баруун талд нийтийн “Халуун ус”-ны газартай болох
9. Соёлын төвийн материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн соёлын төвийн барилгыг шинээр барих.



10. Хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээг зайны болон нүүдлийн хэлбэрт оруулан соёлын үйлчилгээг сайжруулна.
11. Орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн соёлын өв сурталчлах төв болгоно.
12. Нийтийн биен тамир спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өргөжүүлэн сумын спорт заалыг тогтмол ажиллагаатай болгож спортын секц дугуйлан хичээллүүлнэ.

#### **5. Гэр бүл нийгмийн хамгаалал**

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төр иргэний нийгмийн байгууллагын хамтарсан сүлжээг бий болгоно
2. Залуучуудыг амьдралын зөв дадалд сургах, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх хөгжүүлэхэд чиглэсэн сургалт лекцүүдийг зохион байгуулна.
3. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхитэй оролцуулах, тэдний амьдралын туршлага, мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэргээр үл ажиллагааг өргөжүүлнэ.

#### **6. Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээ**

1. Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэдийн үнэлгээ өгдөг тогтолцоог боловсронгуй болгоно.
2. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах шинжлэх ухаан технологийн ололтыг ашиглаж төрийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.
3. БИНХ-ын үйл ажиллагааг өргөжүүлэн явуулж иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлнэ,
4. Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгоход чиглэсэн шинэ дэвшилттэй хэлбэрийн үйлчилгээг нэвтрүүлж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулна.
5. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч, эрхзүйн туслалцааны бие даасан үйлчилгээг бий болгоно.
6. Иргэд хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахын өмнө иргэд, хуулийн этгээдийг оролцуулсан нийтийн сонсгол хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллах.
7. Гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил зэрэг нийгмийн сөрөг үзэллүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, Монгол ёс заншил, ухамсрыг хүүхэд залуучуудад төлөвшүүлэн зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, ТББ-ын оорлцоотойгоор хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
8. Гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоох зорилгоор сумын төвд хяналтын камерын тоог нэмж, нэгдсэн систем нэвтрүүлэх.
9. Цагдаагийн тасгийг шинэ байртай болгож цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

ХУЖИРТ СУМЫН МАН-ЫН ХОРОО

